



48

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 28

Номгон

**Албан тушаалын тодорхойлолт
батлах саналыг уламжлах тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.7, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлд батлах зөвшөөрлийг олгох саналыг уламжилсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтод Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу өөрчлөлтийг бүрэн хийж, холбогдох материалыг бүрдүүлэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Салбар Зөвлөлийн Нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Сарангарав/-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

642213181